



**ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2022.04.20 № 366.
танай _____ -ны № _____ -т

Г ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА, ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН
ЗАХИРАГЧ, А.ИШДОРЖ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-д заасны дагуу Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Өвөрхангай аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бodoх бүртгэлийн тухай хууль, Улсын секторын наягтлан бodoх бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Өвөрхангай аймгийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болсон. Үүнд:

- Баянтээг ХК нь нийгмийн өмнө хулээх хариуцлагын хүрээнд нийт цэвэр ашгийн 10 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгөөр хөрөнгө оруулалтын ажил хийх эрхтэй боловч 10 хувиас хэтрүүлэн 2021 онд 1,000.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт хуваарилан зарцуулсан.
- Баянтээг ХК нь 2,376.8 сая төгрөгийн үл хөдлөх хөрөнгөдөө хөрөнгийн дахин үнэлгээ хийгээгүй.
- ӨВ-ЭКО МИЙТ ОНӨААТҮГ нь 2021 оны санхүүгийн тайландаа хуулийн хугацаанд аудит хийлгээгүй зэрэг зөрчлүүд нь УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.4, Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8, МУ-ын Засгийн газрын 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 207 дугаар тушаалыг зөрчсөн, санхүүгийн тайлангийн аудитын нийцсэн бөгөөд зохистой байх, үнэн зөв байдал, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлүүдтэй нийцэхгүй байна.

015030738

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага
Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай
хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох
бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу
илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж,
хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх
материаллаг буруу илэрхийлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх
үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан
гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч
материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн
аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд
дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн
эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ